



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 04 дугаар сарын 08

Дугаар А/49

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн
хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.13.1, 37.14.2, Сангийн сайдын 2024 оны “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 53 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн нарийвчилсан хуваарь”-ийг нэгдүгээр хавсралтаар, “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.


Хоёр. Төсвийн санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгохыг Санхүү, бүртгэлийн газар /Б.Даваахүү/, төсвийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

Гурав. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган ажиллахыг төсвийг захиран зарцуулах эрх бүхий энэ тушаалын нэг дэх хэсэгт заасан нийгмийн даатгалын байгууллагуудын албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

Дөрөв. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Тав. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газар /Б.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.МӨНХЗУЛ

152401027

